



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2021.02.23 № 49

танай _____-ны № _____-т

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Д.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/64 дүгээр тушаал, Төрийн аудитын байгууллагын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Байгаль орчин аялал жуулчлалын газар"-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, тайланг асуудлын бүртгэл, төлбөрийн акт, албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитын тайланд тусгагдсан алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, төсөв, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллах, аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийг актыг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны дотор гаргаж ирүүлэхийг зөвлөж байна.

Хавсралт 32 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

Аймаг нэгтгэл бодлого
Ц.Цэрэншигээ
Аудитын дүгнэлт зөвлөмжийн гэрэллэлтийг
хэргийн ажиллагааг зөвхөн хяналтын
үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллах
2021.02.23

083040169

| | |
|------------------------|--|
| Ажлын баримтын нэр: | Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл |
| Ажлын баримтын дугаар: | В501 |
| Аудитын код: | ГСА-2021/18/СТА-ТШЗ |
| Аудитын нэр: | Байгаль орчин, аялал жуулчлалын газар |

| № | Аудитын чиглэл | Тоо | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний | |
|-----------------|-----------------------------------|-----|--|-------------------|--|---|--|-------------------------|--|-----------------------------|
| | | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Үндсэн хөрөнгийн данс | 1 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзыг үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн | 230,000 | Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн | Залруулга хийгдсэн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 2 | Бараа материалын данс | 11 | Бусад хангамжийн материалаас үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн хөрөнгийн үр дүнгийн тайланд орлого, зарлагаар бүртгэсэн | 77,814,169 | Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн | Залруулга хийгдсэн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 3 | Цалингийн зардал | 18 | Ажилчдын ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн боловч анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй | 1,170,251 | Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн | Залруулга хийгдсэн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 4 | Бараа материалын данс | 1 | Тээвэр шатахууны зардлыг хэрэглээнээс илүү нөөц бэлтгэж төсөвт буцаан төвлөрүүлээгүй. | 1,799,000 | Төлбөрийн акт тогтоох | Тайлбартай | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоосон | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 5 | Мөнгөн гүйлгээний тайлан | 1 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан | 3,129,000 | Залруулга хийх | Зөвшөөрсөн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 6 | Үндсэн хөрөнгийн тодруулга тайлан | 1 | Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг худалдаж авсан хөрөнгөөр тайлагнасан | 9,766,000 | Залруулга хийх | Зөвшөөрсөн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 7 | Зардал | 1 | БХНСАХЗ-ыг үр дүнгийн тайланд илүү тусгасан | 293,304 | Залруулга хийх | Зөвшөөрсөн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 9 | Хууль тогтоомжийн хэрэгжилт | 3 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож, 1 ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг баталгаажуулалгүй цахим хуудсанд байршуулсан | - | Албан шаардлага өгөх | Зөвшөөрсөн | Албан шаардлага өгөх | Албан шаардлага өгсөн | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 10 | Дотоод хяналт | 1 | Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй. | - | Албан шаардлага өгөх | Зөвшөөрсөн | Албан шаардлага өгөх | Албан шаардлага өгсөн | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| Нийт дүн | | | | 94,201,724 | | | | | | |

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

/Ц.Батсайхан/

2021.02.22

Дарга

/Д.Мөнх-Эрдэнэ/

2021.02.22

Анхан шатанд хянасан:

Нягтлан бодогч

/Ц.Цэрэнчимэд/

2021.02.22

Аудитын менежер

/Г.Наранбаяр/

2021.02.22

Хоёр дахь шатанд хянасан:

Тэргүүлэх аудитор

/Б.Сарантуяа/

2021.02.22

Танилцаж зөвшөөрсөн:



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2021/18/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойр хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 7054-3156

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 7054-3179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Батсайхан

Утас: 7054-3179

Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ГСА | Говьсүмбэр аймаг |
| АИТХТ | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид |
| АОНХ | Аймгийн орон нутгийн хөгжлийн сан |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| БОАЖЯ | Байгаль орчин аялал жуулчлалын яам |
| БХНСАХ | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал |

Агуулга

| | |
|---|----|
| 1.Төрийн аудитын санал, дүгнэлт | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 10 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 11 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 13 |
| 3.Аудитын тайлан | 14 |
| 3.1. Ерөнхий зүйл | 14 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй..... | 14 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт..... | 14 |
| 3.4. Материаллаг байдал..... | 14 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 15 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт..... | 17 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл..... | 18 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 18 |
| 3.9. Аудитын илрүүлэлт | 19 |
| Залруулсан алдаа..... | 19 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил..... | 19 |
| Аудитын зөвлөмж | 20 |
| 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд | 20 |
| 4. Менежментийн захидал..... | 21 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 22 |



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Д.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

2021.02.23 № 20

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Байгаль орчин аялал жуулчлалын газар”-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн “Байгаль орчин аялал жуулчлалын газар”-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 164 арга хэмжээ төлөвлөж 156 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан ба аймгийн ТЕЗ-аас гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.6 %-тай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

003020031

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|-----------------------------------|----------------|-----------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 150,514,515.15 | 58,212,756.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 5,988,690.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 00.00 | 5,988,690.00 |
| 3121 | Төгрөг | 00.00 | 5,988,690.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 00.00 | 5,988,690.00 |
| 33 | АВЛАГА | 7,964.00 | 00.00 |
| 335 | Бусад авлага | 7,964.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 7,964.00 | 00.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 00.00 | 1,000,000.00 |
| 34200 | Төсөвт байгууллага | 00.00 | 1,000,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 122,740,551.15 | 51,224,066.00 |
| 354 | Хангамжийн материал | 122,440,551.15 | 51,224,066.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 20,955,200.00 | 33,035,245.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,684,170.15 | 10,020,313.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,683,300.00 | 707,800.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 608,912.00 | 2,082,408.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 86,508,969.00 | 5,378,300.00 |
| 35600 | Мал амьтад | 300,000.00 | 00.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 27,766,000.00 | 00.00 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 27,766,000.00 | 00.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 357,081,086.93 | 475,147,108.54 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 357,081,086.93 | 475,147,108.54 |
| 392 | Биет хөрөнгө | 34,196,033.93 | 151,821,055.54 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -369,444.36 | -427,777.68 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 40,256,000.00 | 14,200,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -38,396,000.00 | -620,000.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 29,158,413.48 | 24,527,137.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -16,501,199.97 | -9,688,905.39 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 3,850,470.00 | 3,884,500.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3,002,205.22 | -2,092,868.59 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 00.00 | 110,443,805.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -7,604,834.76 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 15,700,000.00 | 15,700,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 322,885,053.00 | 323,326,053.00 |
| 39301 | Программ хангамж | 4,180,053.00 | 4,180,053.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -495,000.00 | -54,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 319,200,000.00 | 319,200,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 507,595,602.08 | 533,359,864.54 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 507,595,602.08 | 533,359,864.54 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 507,595,602.08 | 533,359,864.54 |

| | | | |
|-------|--|-----------------------|-----------------------|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 361,223,069.00 | 361,223,069.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 361,223,069.00 | 361,223,069.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 146,337,570.58 | 158,196,833.04 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 146,337,570.58 | 146,337,570.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 11,859,262.46 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 34,962.50 | 13,939,962.50 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>507,595,602.08</u> | <u>533,359,864.54</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 417,807,586.00 | 413,821,564.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 12,614,986.00 | 68,658,964.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,614,986.00 | 68,658,964.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,614,986.00 | 65,558,964.00 |
| 120009 | Бусад орлого | 5,437,500.00 | 6,640,270.00 |
| | | 00.00 | 3,100,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 405,192,600.00 | 345,162,600.00 |
| | | 00.00 | 3,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| | | 00.00 | 3,100,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| | | 00.00 | 400,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 405,192,600.00 | 341,662,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 405,192,600.00 | 341,662,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 409,663,593.48 | 400,963,625.06 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 409,663,593.48 | 400,963,625.06 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 350,533,912.09 | 373,796,926.27 |
| 210101 | Үндсэн цалин | 95,776,920.00 | 114,562,922.00 |
| 210102 | Нэмэгдэл | 84,239,998.00 | 85,103,403.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,230,922.00 | 25,309,519.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,306,000.00 | 4,150,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,375,011.61 | 14,560,712.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,866,370.61 | 10,183,964.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 925,455.00 | 1,198,113.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 740,363.00 | 908,091.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 167,529.00 | 206,413.46 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,675,294.00 | 2,064,129.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,202,602.00 | 4,724,525.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 00.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,025,354.00 | 3,819,146.00 |
| 210304 | Байрны түрээс | 657,248.00 | 385,379.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 520,000.00 | 520,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 15,197,952.50 | 14,309,858.65 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 848,640.00 | 1,403,555.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,900,676.00 | 1,619,600.00 |
| | | 965,466.50 | 1,692,313.50 |

| | | | |
|--------|--|-----------------------|----------------------|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 60,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 381,500.00 | 68,550.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 9,041,670.00 | 9,465,840.15 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,252,000.00 | 1,020,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,252,000.00 | 1,020,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,558,500.00 | 651,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,558,500.00 | 651,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,068,400.00 | 4,322,180.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 80,000.00 | 2,799,920.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 756,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 533,600.00 | 599,260.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 192,800.00 | 92,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 24,000.00 | 19,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 218,102,525.98 | 219,645,727.91 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 201,220,003.00 | 203,708,104.36 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 240,000.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,642,522.98 | 15,937,623.55 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 59,129,681.39 | 27,166,698.79 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,386,016.00 | 1,841,136.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,386,016.00 | 1,841,136.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 57,743,665.39 | 25,325,562.79 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 57,743,665.39 | 25,325,562.79 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>8,143,992.52</u> | <u>12,857,938.94</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 18,812,765.92 | 998,676.48 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 18,812,765.92 | 230,000.00 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 768,676.48 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -18,812,765.92 | -998,676.48 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>-10,668,773.40</u> | <u>11,859,262.46</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 410,630,100.00 | 354,902,870.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,437,500.00 | 9,740,270.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,437,500.00 | 9,740,270.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,437,500.00 | 6,640,270.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,437,500.00 | 6,640,270.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 3,100,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 405,192,600.00 | 345,162,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00.00 | 3,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 3,100,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 400,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 405,192,600.00 | 341,662,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 405,192,600.00 | 341,662,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 410,630,100.00 | 348,914,180.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 410,630,100.00 | 348,914,180.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 351,500,418.61 | 320,747,481.21 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 95,776,920.00 | 114,562,922.00 |
| 210101 | Үндсэн цалин | 84,239,998.00 | 91,255,301.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,230,922.00 | 19,157,621.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,306,000.00 | 4,150,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 11,375,011.61 | 14,560,712.71 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,866,370.61 | 10,183,964.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 925,455.00 | 1,198,113.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 740,363.00 | 908,091.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 167,529.00 | 206,413.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,675,294.00 | 2,064,129.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,202,602.00 | 4,724,525.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,025,354.00 | 3,819,146.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 657,248.00 | 385,379.00 |
| 210304 | Байрны түрээс | 520,000.00 | 520,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,627,412.00 | 6,556,249.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,043,500.00 | 1,043,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,830,300.00 | 3,396,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,221,662.00 | 1,884,349.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 139,950.00 | 140,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 392,000.00 | 92,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 00.00 | 960,000.00 |

| | | | |
|--------|--|----------------|----------------|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 960,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 5,100,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,200,000.00 | 3,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,558,500.00 | 651,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,558,500.00 | 651,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,160,400.00 | 4,322,180.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 172,000.00 | 2,799,920.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 756,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 533,600.00 | 599,260.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 192,800.00 | 92,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 24,000.00 | 19,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 224,799,573.00 | 169,309,892.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 224,289,573.00 | 169,041,692.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 510,000.00 | 268,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 59,129,681.39 | 28,166,698.79 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,386,016.00 | 1,841,136.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,386,016.00 | 1,841,136.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 57,743,665.39 | 25,325,562.79 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 57,743,665.39 | 25,325,562.79 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 1,000,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,000,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 5,988,690.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 5,988,690.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 5,988,690.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 361,223,069.00 | 34,962.50 | 146,337,570.58 | 507,595,602.08 |
| D01 | 2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 361,223,069.00 | 34,962.50 | 146,337,570.58 | 507,595,602.08 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 361,223,069.00 | 34,962.50 | 146,337,570.58 | 507,595,602.08 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 13,905,000.00 | 00.00 | 13,905,000.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 11,859,262.46 | 11,859,262.46 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 361,223,069.00 | 13,939,962.50 | 158,196,833.04 | 533,359,864.54 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 341,662,600.00 | 316,337,037.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 341,662,600.00 | 316,337,037.21 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 338,662,600.00 | 314,495,901.21 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 124,320,900.00 | 114,562,922.00 |
| 210101 | Үндсэн цалин | 101,065,700.00 | 91,255,301.00 |
| 210102 | Нэмэгдэл | 18,942,800.00 | 19,157,621.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,312,400.00 | 4,150,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,865,000.00 | 14,560,712.71 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,868,000.00 | 10,183,964.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,249,200.00 | 1,198,113.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 999,300.00 | 908,091.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 249,900.00 | 206,413.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,498,600.00 | 2,064,129.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,860,200.00 | 4,724,525.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 173,800.00 | 00.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,474,400.00 | 3,819,146.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 692,000.00 | 385,379.00 |
| 210304 | Байрны түрээс | 520,000.00 | 520,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,865,900.00 | 6,556,249.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,043,500.00 | 1,043,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,396,400.00 | 3,396,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,194,000.00 | 1,884,349.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140,000.00 | 140,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 92,000.00 | 92,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 960,000.00 | 960,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 960,000.00 | 960,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,100,000.00 | 5,100,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,300,000.00 | 3,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,605,900.00 | 651,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,605,900.00 | 651,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,883,200.00 | 1,822,180.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 300,000.00 | 299,920.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 756,000.00 | 756,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 647,300.00 | 599,260.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 94,700.00 | 92,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 19,200.00 | 19,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 173201500.00 | 165558312.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 172,933,300.00 | 165,290,112.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 268,200.00 | 268,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3000000.00 | 1841136.00 |

| | | | |
|--------|---|----------------|----------------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,000,000.00 | 1,841,136.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 1,841,136.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 341,662,600.00 | 316,337,037.21 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 341,662,600.00 | 316,337,037.21 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 341,662,600.00 | 316,337,037.21 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 5,988,690.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|--|----------|--------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 3,500,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 3,500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 3,500,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 3,500,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 3,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3,500,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Д.Мөнх-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгаль орчин аялал жуулчлалын газар нь “Иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийн хөгжлийг өнөө ирээдүй үеийн эрх ашгийн үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоороо нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор дараах зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

Зорилгыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу жил бүрийн байгууллагын үйл ажиллагааг төлөвлөн зорилго зорилтоо биелүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3-р улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 238,358.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,383.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 400,963.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож, 4,009.6 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,764.3 мянган төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|------------------|------------------|-----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 5,988.7 | 5,988.7 |
| Авлага | 8.0 | | -8.0 |
| Урьдчилгаа | | 1,000.0 | 1,000.0 |
| Бараа материал | 150,506.6 | 51,224.1 | -99,282.5 |
| Үндсэн хөрөнгө | 357,081.1 | 475,147.1 | 118,066.0 |
| Нийт хөрөнгө | 507,595.6 | 533,359.9 | 25,764.3 |
| Өр төлбөр | | | 0.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 507,595.6 | 533,359.9 | 25,764.3 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 507,595.6 | 533,359.9 | 25,764.3 |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,988.7 мянган төгрөг болж 5,988.7 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд Төрийн сангийн нэгдсэн данснаас ахмадын санг салгаж байгууллагын нэрээр харилцах данс нээж бүртгүүлснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж 8.0 мянган төгрөгөөр буурсан нь шуудан холбооны авлагыг суутгаж тооцоноос шалтгаалжээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,000.0 мянган төгрөг болж 1,000.0 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансанд гүйлгээ хаагдахад төвлөрсөн урамшууллын орлогыг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 51,224.1 мянган төгрөг болж 99,282.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд бараа материал акталсан болон үндсэн хөрөнгөнд бараа материал шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 150,506.6 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 20,146.9 мянга, ОНХС-гаас үнэ төлбөргүй тусгай хамгаалалттай газар нутгийн самбар 400.0 мянга, сурталчилгааны нугалбар 2,000.0 мянга, БОАЖЯ-наас байгаль хамгаалагчийн багц хувцас 774.4 мянга, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2020.04.28-ны өдрийн дүгнэлтээр 370.0 мянган төгрөгийн акталж данснаас хассан тоног төхөөрөмжийг үнэлж бүртгэсэн зэрэг 23,691.3 мянган төгрөгөөр

нэмэгдэж, зарцуулсан 6,840.7 мянга, АИТХТ-ийн 2020.06.30-ны өдрийн 37 тоот тогтоолоор бусад хангамжийн материалын данснаас 77,814.1 мянган төгрөгийн материалыг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж, Газрын даргын 2020.06.30-ны өдрийн А/11 тоот тушаалаар 9,465.6 мянган төгрөгийн материалыг акталж, Сум дундын ойн ангид 1,087.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж, нөөцийн бараа материалаас АИТХТ-ийн 2020.12.28-ны өдрийн 79 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар зараагийн хүн чулууны тохижилтын ажил 9,766.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлж, тарвага сэргээн нутагшуулах ажлын барьцааг чөлөөлж 18,000.0 мянган төгрөгөөр зардлаар бүртгэсэн зэрэг нийт 122,973.4 мянган төгрөгөөр хасагдаж, 51,224.1 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд бичиг хэргийн материал 33,035.2 мянга, аж ахуйн материал 10,020.3 мянга, сэлбэг хэрэгсэл 707.8 мянга, түлш шатах тослох материал 2,082.4 мянга, бусад хангамжийн материал 5,378.4 мянган төгрөг тус тус байна.

Оны эцэст тээвэр шатахууны зардлаас 846.4 мянган төгрөгийн шатахууны худалдан авалт хийж, бараа материалын илүүдэл нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 495,635.4 мянган төгрөг болж 79,790.5 мянган төгрөгөөр өссөн нь АОНХС болон Орон нутгийн хөрөнгө оруулалт, БОАЖЯ-наас үнэгүй хөрөнгө хүлээн авсан, бараа материалаас үндсэн хөрөнгө шилжүүлж авсан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлсэн зэргээс шалтгаалжээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,129.0 мянга, АИТХТ-ийн 2020.04.15-ны өдрийн 25 дугаар тогтоолын 09 дүгээр хавсралтаар УТХО-аар худаг 28,830.1 мянга, АИТХТ-ийн 2020.12.28-ны өдрийн 79 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар Орон нутгийн хөрөнгө оруулалтаар компьютер 1,820.5 мянга, 2020.12.28-ны өдрийн 79 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар зараагийн хүн чулууны тохижилтын ажил 9,766.0 мянга, 7 дугаар хавсралтаар мотоцикл 1,860.0 мянга, давхар хаягдал нягтруулан шахагч төхөөрөмж 22,863.6 мянга, АИТХТ-ийн 2020.06.30-ны өдрийн 37 тоот тогтоолоор бусад хангамжийн материалын данснаас 77,814.2 мянган төгрөгийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж авсан, АИТХТ-ийн 2020.06.30-ны өдрийн 35 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг 13,905.0 мянган төгрөгөөр дахин үнэлсэн, нийт 159,988.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

АИТХТ-ийн 2020.06.30-ны өдрийн 42 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтаар акталсан мотоцикл, тоног төхөөрөмж 3,515.5 мянга, АИТХТ-ийн 2020.06.30-ны өдрийн 36 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд шилжүүлсэн тоног төхөөрөмж 1,530.0 мянга, АИТХТ-ийн 2020.12.28-ны өдрийн 82 дугаар тогтоолоор 28,830.1 мянган төгрөгийн худгийг Сум дундын ойн ангид шилжүүлсэн, АИТХТ-ийн 2020.06.30-ны өдрийн 35 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 46,322.2 мянга, нийт 80,197.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 441.0 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн санхүүгийн программыг 495.0 мянган төгрөгөөр дахин үнэлсэн, архивын программд тайлант онд 54.0 мянган төгрөгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөр дансыг үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 533,359.9 мянган төгрөг болж 25,764.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг 13,905.0 мянган төгрөгөөр дахин үнэлсэн, 11,859.3 мянган төгрөгийн үр дүнтэй ажилласан зэргээс шалтгаалжээ.

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,986.0 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь санхүүжилтийн орлого 63,530.0 мянган төгрөгөөр буурч, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 56,044.0 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 3,500.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Энэ нь Ковид цар тахлын улмаас БХНСАХЗ-ыг төсвийн тодотголоор хассан, БОАЖЯ, АОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 8,699.9 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь бараа үйлчилгээний зардал байна. Энэ нь тайлант онд Ковид-19 цар тахлын улмаас төсвийн тодотголоор зардал хасагдсан нь нөлөөлжээ

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 426,613.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 426,613.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 59,784.3 мянган төгрөгөөр бууруулж, 366,829.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөлд тусгагдсан саналаас 10,135.1 мянган төгрөгийн цалин, НДШ-ийн зардал, 159.9 мянган төгрөгийн хангамжийн материалын зардал, 341.8 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал нийт 10,636.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,333.9 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,950.0 мянга, дотоод албан томилолтын зардлыг 1,894.1 мянга, БХНСАХ-ний зардлыг 63,571.3 мянга, биеийн тамир уралдаан тэмцээний зардлыг 400.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 671.8 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 600.0 мянга, нийт 70,421.1 мянган төгрөгөөр бууруулж баталсан нь нөлөөлжээ.

Анх 366,829.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор БХНСАХ-ний зардлыг 25,166.7 мянган төгрөгөөр бууруулж, 341,662.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага” 1 хөтөлбөрийн хүрээнд 80801-үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 140,562.6 мянга, 80802-ажил олгогчийн тэтгэмж урамшуулал арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,000.0 мянга, 81701-Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлэхээр 198,100.0 мянга, нийт 341,662.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 341,662.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 341,662.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 316,337.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 25,325.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 316,337.0 мянган төгрөг буюу 92.6 хувьтай байгаа нь дутуу ажилласан 1 орон тооны цалин, НДШ-ийн зардлыг 12,062.2 мянга, байр ашиглалттай холбогдсон зардлыг 2,135.6 мянга, хангамжийн бараа материалыг 309.7

мянга, дотоод албан томилолтын зардлыг 1,954.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 61.1 мянга, БХНСАХ-ний зардлыг 7,643.2 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 1,158.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 341,662.6 мянга, үнэ төлбөргүй бараа материал, үндсэн хөрөнгийн орлого 58,918.6 мянга, ахмадын сангийн орлого 6,640.3 мянга, нөхөн төлбөрийн орлого 3,100.0 мянга, нэмэлт санхүүжилт дансны орлого 3,500.0 мянга, нийт 413,821.5 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт 341,662.6 мянга, ахмадын сангийн орлого 6,640.3 мянга, нөхөн төлбөрийн орлого 3,100.0 мянга, нэмэлт санхүүжилт дансны орлого 3,500.0 мянга, нийт 354,902.9 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс 400.0 мянга, БОАЖЯ-наас зохион байгуулсан “Хандлагаа өөрчилье” багц ажлын “Хоггүй цэвэрхэн Монгол” төслийн санхүүжилт 3,100.0 мянга, нийт 3,500.0 мянган төгрөгийг хүлээн авч, орон нутгийн телевизээр мэдээ, мэдээлэл түгээх зардалд 2,100.0 мянган төгрөгийн зарцуулж, 1,400.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт дансны эх үүсвэр, зарцуулалттай холбоотой зөрчил илрээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байгаа бөгөөд 147 мэдээлэл хугацаандаа оруулсан байна.

Шилэн дансны хуудсанд байршуулсан мэдээллийг мөнгөн гүйлгээ болон анхан шатны баримт материалтай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 6 дугаар сард хугацаа хоцроосон
2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг 12 дугаар сард баталгаажуулалгүй оруулсан

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 10,224.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|----------|---------------------|----------|---------|----------|-------|-----|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 10,224.2 | 3 | 10,224.2 | | | |
| Нийт дүн | 3 | 10,224.2 | 3 | 10,224.2 | | | |

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 94,201.7 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс, 92,402.7 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 1,799.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 2 зөрчилд 2 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах 6 алдааны залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулсан бөгөөд үүний 79,214.4 мянган төгрөгийн 3 алдааг завсрын аудитаар илрүүлж зөвлөмж өгч залруулсан ба бусад алдааг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 230.0 мянган төгрөгийг үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн
2. Бусад хангамжийн материалаас үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн 77,814.1 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлого, зарлагаар бүртгэсэн
3. Ажилчдын ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн боловч 1,170.3 мянган төгрөгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй
4. Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан 3,129.0 мянган төгрөгийг зардлын ангилал зөрүүтэй тайлагнасан
5. Үнэ төлбөргүй авсан 9,766.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авсан хөрөнгөөр тайлагнасан
6. БХНСАХЗ-ыг үр дүнгийн тайланд 293.3 мянган төгрөгөөр илүү тусгасан

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,799.0 мянган төгрөгийн залруулагдаагүй 3 алдаа, зөрчил илэрснээс 1,799.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант оны төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүйгээс тээвэр шатахууны зардлаас 1,799.0 мянган төгрөгийн илүү нөөц бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 7 дугаар зүйлийн 7.7, 45 дугаар зүйлийн 45.2 дахь заалтуудыг зөрчсөн, үнэн зөв байх, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож, 1 ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг баталгаажуулалгүй цахим хуудсанд байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.10-т “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан

мэдэгдлийг хавсаргасан байна”, 7 дугаар зүйлийн 7.1.1-т “Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.5-т “шилэн дансны нэгдсэн цахим хуудасны бүх түвшний хэрэглэгчид дараах үүрэгтэй” заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

3. Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5-д “төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд зөвлөмж өгөгдөөгүй болно.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна

4. Менежментийн захидал

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд зөвлөмж өгөгдөөгүй болно.
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | |
|------------------------------|--|--|
| Огноо: 2021 | Аудитын нэр: Аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: ГСА-2021/18/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|------------|---------------------------------------|---|-------------------------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзыг үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн | 230.0 | Залруулга | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |
| 2 | Төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлэлгүй, үндсэн үйл ажиллагааны хэрэгцээнээс илүүдэл шатахууны нөөц бүрдүүлсэн. | 1,799.0 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |
| 3 | Бусад хангамжийн материалаас үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн хөрөнгийн үр дүнгийн тайланд орлого, зарлагаар бүртгэсэн | 77,814.1 | Залруулга | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |
| 4 | Ажилчдын ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн боловч анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй | 1,170.3 | Залруулга | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |
| 5 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан | 3,129.0 | Залруулга | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |
| 6 | Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг худалдаж авсан хөрөнгөөр тайлагнасан | 9,766.0 | Залруулга | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |
| 7 | БХНСАХЗ-ыг үр дүнгийн тайланд илүү тусгасан | 293,3 | Залруулга | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |
| 8 | Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй. | 0.0 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |
| 9 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож, 1 ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг | 0.0 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ Ц.Цэрэнчимэд |

| | | | | | | |
|--|---|-------|-----------------|--|--|--|
| | баталгаажуулалгүй хуудсанд байршуулсан | цахим | | | | |
| | ДҮН | | 94,201.7 | | | |

| | | |
|------------------------|--|---------------------------------------|
| Ажлын баримтын нэр: | Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл | |
| Ажлын баримтын дугаар: | | B501 |
| Аудитын код: | | ГСА-2021/18/СТА-ТШЗ |
| Аудитын нэр: | | Байгаль орчин, аялал жуулчлалын газар |

| № | Аудитын чиглэл | Тоо | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний | |
|-----------------|-----------------------------------|-----|--|-------------------|--|---|--|-------------------------|--|-----------------------------|
| | | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Үндсэн хөрөнгийн данс | 1 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзыг үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн | 230,000 | Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн | Залруулга хийгдсэн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 2 | Бараа материалын данс | 11 | Бусад хангамжийн материалаас үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн хөрөнгийн үр дүнгийн тайланд орлого, зарлагаар бүртгэсэн | 77,814,169 | Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн | Залруулга хийгдсэн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 3 | Цалингийн зардал | 18 | Ажилчдын ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн боловч анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй | 1,170,251 | Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн | Залруулга хийгдсэн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 4 | Бараа материалын данс | 1 | Тээвэр шатахууны зардлыг хэрэглээнээс илүү нөөц бэлтгэж төсөвт буцаан төвлөрүүлээгүй. | 1,799,000 | Төлбөрийн акт тогтоох | Тайлбартай | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн акт тогтоосон | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 5 | Мөнгөн гүйлгээний тайлан | 1 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан | 3,129,000 | Залруулга хийх | Зөвшөөрсөн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 6 | Үндсэн хөрөнгийн тодруулга тайлан | 1 | Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг худалдаж авсан хөрөнгөөр тайлагнасан | 9,766,000 | Залруулга хийх | Зөвшөөрсөн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 7 | Зардал | 1 | БХНСАХЗ-ыг үр дүнгийн тайланд илүү тусгасан | 293,304 | Залруулга хийх | Зөвшөөрсөн | | | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 9 | Хууль тогтоомжийн хэрэгжилт | 3 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож, 1 ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг баталгаажуулалгүй цахим хуудсанд байршуулсан | - | Албан шаардлага өгөх | Зөвшөөрсөн | Албан шаардлага өгөх | Албан шаардлага өгсөн | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| 10 | Дотоод хяналт | 1 | Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй. | - | Албан шаардлага өгөх | Зөвшөөрсөн | Албан шаардлага өгөх | Албан шаардлага өгсөн | Дарга, нягтлан бодогч | Д.Мөнх-Эрдэнэ, Ц.Цэрэнчимэд |
| Нийт дүн | | | | 94,201,724 | | | | | | |

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

[Signature]

/ Ц.Батсайхан/

Анхан шатанд хянасан

[Signature]

/ Г.Наранбаяр /

Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан

[Signature]

Тэргүүлэх аудитор

[Signature]

/ Б.Сарантуяа /

CA9055 90130

Танилцаж зөвшөөрсөн:

2021.02.22

Дарга

/ Д.Мөнх-Эрдэнэ/

2021.02.22

Нягтлан бодогч

/ Ц.Цэрэнчимэд /

2021.02.22

2021.02.22

2021.02.22



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 20/A0860273
ГСА-2021/18/СТА-Т243

Чойр

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Байгаль орчин аялал жуулчлалын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тээвэр шатахууны зардлын зарцуулаагүй үлдэгдэл 1,799.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэлгүй, хэрэглээнээс илүү нөөц бэлтгэсэн, төсвийг хэмнэлттэй, зөв зохистой удирдан зохион байгуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэлгүй хэрэглээнээс илүү шатахууны нөөц бэлтгэсэн 1,799,000.00 төгрөгийг барагдуулж, аймгийн Төрийн сан дахь орон нутгийн орлогын "Төсөвт байгууллагын өөрийн орлого" 100220000954 тоот дансанд төвлөрүүлэх;

0801000214

2. Актын биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Д.Мөнх-Эрдэнэ, нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд нарт хариуцуулав.

| | | |
|--------------------------|--|-------------|
| АХЛАХ АУДИТОР | АКТ ТОГТООСОН:  | Ц.БАТСАЙХАН |
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР |  421714445 УСА0055 9010- | Б.САРАНТУЯА |

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 24/А0860273

Чойр

ГСА-2021/18/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Байгаль орчин, аялал жуулчлалын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож, 1 ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг баталгаажуулалгүй цахим хуудсанд байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6.10-т Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна", 7 дугаар зүйлийн 7.1.1-т "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5-т "шилэн дансны нэгдсэн цахим хуудасны бүх түвшний хэрэглэгчид дараах үүрэгтэй" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв, бүрэн байршуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

080000357

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Д.Мөнх-Эрдэнэ, нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР


Ц.БАТСАЙХАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА



Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
2021 оны 24/А.08.02.73 дугаартай албан шаардлагын хавсралт



“Байгаль орчин аялал жуулчлалын газар”-ын албан шаардлагын жагсаалт

| Д/Д | Мэдээлээгүй зөрчлийн утга | Мэдээлээгүй тушаал шийдвэрийн дугаар, орлого, зарлагын он сар өдөр |
|-----|--|--|
| 1 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож цахим хуудсанд байршуулсан байна. | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 6 дугаар сард хугацаа хоцроосон |
| 2. | Ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг баталгаажуулалгүй цахим хуудсанд байршуулсан байна. | Өвс худалдан авсан гэрээ байгуулсантай холбоотой ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг 12 сард баталгаажуулалгүй оруулсан |



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 25/A0860273
ГТА-2021/18/СТА-ТМЗ

Чойз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Байгаль орчин, аялал жуулчлалын газар"-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5-д "төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;


¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

086000359

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Д.Мөнх-Эрдэнэ, нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР




Ц.БАТСАЙХАН


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА



Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
2021 оны 25/А0860273 дугаартай албан шаардлагын хавсралт



“Байгаль орчин аялал жуулчлалын газар”-ын албан шаардлагын жагсаалт

| Д/Д | Илэрсэн зөрчлийн утга | Мөнгөн дүн |
|-----|---|---|
| 1 | Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй. | Шивээ-Овоо ХК-иас нүүрс худалдан авсан баримт -100,254.00 төгрөгөөр дутуу |
| 2 | | Сод монгол группээс шатахуун худалдан аваагүй байхад 40,000.00 төгрөгөөр илүү |